



ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 11

Чингис хот

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний
үйлдвэрлэл, технологи, нийтийн хоолны
асуудал хариуцсан мэргэжилтний сул
орон тоонд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.4, 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6, 3.5, 3.5.4, 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7.1, 7.2, 7.4, 7.6, 7.7, 2019 оны 16 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, 2020 оны 141 дүгээр “Төрийн албаны тусгай шалгалтыг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /72/ авсан Хаш-Эрдэнийн Нандин-Эрдэнийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний үйлдвэрлэл, технологи, нийтийн хоолны асуудал хариуцсан мэргэжилтний сул орон тоонд нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч Х.Нандин-Эрдэнийг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг ажлын 14 өдрийн дотор албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Ж.Энх-Амгалан/-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргад хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ж.Саруултөгс/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР